

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.12 № 127
танай _____-ны № _____-т

АРВАЙХЭЭР ЦЭЦЭРЛЭГЖИЛТ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.МЯГМАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Арвайхээр Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүү тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ нь 2024 онд 4 зорилтыг хэрэгжүүлэх 22 арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 476,300.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 152,300.0 мянга, харилцах дансны эхний үлдэгдлээс 60,996.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 772,550.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 201,388.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, санхүү тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5225020102

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.0	0.0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	87,916,402.14	296,894,252.7
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.0	425,047.8
1.1.4	Бусад авлага	12,054,141.96	8,902,954.4
1.1.6	Бараа материал	317,781,882.45	381,186,732.5
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	417,752,426.55	687,408,987.4
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,110,862,778.80	1,901,328,107.4
1.2.2	Биет бус хөрөнгө	1,587,920,000.00	1,587,920,000.0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,698,782,778.80	3,489,248,107.4
1.3	Нийт хөрөнгийн дүн	4,116,535,205.35	4,176,657,094.8
2.3.1	-төрийн	0.0	129,373,422.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,566,351,387.0	2,566,351,387.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,550,183,818.35	1,480,932,285.8
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,116,535,205.4	4,176,657,094.8
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	4,116,535,205.4	4,176,657,094.8

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	648,326,339.0	973,939,223.6
2	Борлуулалтын өртөг	622,324,888.4	894,934,062.6
3	Нийт ашиг (алдагдал)	26,001,450.6	79,005,161.0
8	Бусад орлого	648,326,339.0	0.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	628,782,352.8	148,256,693.6
11	Санхүүгийн зардал	331,190,120.0	0.0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-285,644,683.2	-69,251,532.6
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-285,644,683.2	-69,251,532.6
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-285,644,683.2	-69,251,532.6
24	Орлогын нийт дүн	-285,644,683.2	-69,251,532.6

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2	Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	2,216,441,477.0	1,835,828,501.6	4,052,269,978.6
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-285,644,683.2	-285,644,683.2
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	349,909,910.0	0.0	349,909,910.0
8	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	2,566,351,387.0	1,550,183,818.4	4,116,535,205.4
2	Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	2,566,351,387.0	1,550,183,818.4	4,116,535,205.4
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	0.0	-69,251,532.6	-69,251,532.6
5	Өмчид гарсан өөрчлөлт	129,373,422.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	129,373,422.0
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	0.0	0.0	2,566,351,387.0	1,480,932,285.8	4,176,657,094.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
1.1	Мөнгөн орлогын дүн	648,326,339.0	973,939,223.6
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	73,812,616.0	973,939,223.6
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	516,884,000.0	0.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	57,629,723.0	0.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	623,101,031.9	695,911,373.0
1.2.1	Ажиллагчдад төлсөн	331,190,120.0	454,043,302.4
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	47,348,349.9	55,913,944.5
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	22,910,926.0	18,193,539.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,664,026.0	15,466,957.0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	414,900.0	472,400.6
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	357,200.0	11,895,900.0
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	439,275.0	690,937.0
1.2.9	Бусад мөнгөн зарлага	201,776,235.0	139,234,392.6
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,225,307.1	278,027,850.6
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	69,050,000.0
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	-69,050,000.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	208,977,850.6
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.0	87,916,402.1
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.0	296,894,252.7

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 973.9 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 973.9 мянган төгрөгийн алдааг залруулж, дахин гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Санхүүгийн тайланд нийт орлого, зардлыг давхардуулан бүртгэж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг алдагдуулсан. Залруулсан НББ-ийн алдаа нь нийт зөрчлийн дүнд ороогүй.

Аудитаар нийт 0.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.0 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хууль эрх зүйн зохицуулалт нь хүчингүй болсон бөгөөд УСНББОУС-д нийцэхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн УСНББОУС-т нийцүүлж боловсруулах шаардлагатай.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байгаагаас илэрсэн зөрчлийг засах үйл ажиллагаа хангалтгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно."гэсэн заалтуудыг зөрчсөн, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дүгээр тогтоол "Нийтлэг журам батлах тухай (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)"-ын хавсралт "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дотоод хяналт шалгалт хийхдээ удирдамж, төлөвлөгөө боловсруулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хугацаатай үүрэг өгч, дотоод хяналтын үр дүнд илэрсэн зөрчлүүд нь засаж сайжирсан байх.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд нийт 4 удаа хуралдаж, 2024 оны төсвийг батлах, байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, гүйцэтгэх захиралд урамшуулал олгох, 2024 оны төсвийн тодотгол батлах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасан "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, ТУЗ-ын хурлаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилж төлөвлөн, хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тайлагнан ТУЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд нийт орлого, зардлыг давхардуулан бүртгэсэн.	1	973939.2	0	0	1	973939.2	1	973939.2	0	0	0	0
Дүн	1	973939.2	0	0	1	973939.2	1	973939.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөрдөж буй НБББББ-т тусгагдсан хууль эрх зүй зохицуулалт хүчингүй, СТОУС-д нийцэхгүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0
Дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0
ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0
Дүн	3	0	0	0	0	0	3	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР